



ДУНДГОВЬ АЙМАГ
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 4/07

Мандалговь


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, орчны эрүүл ахуйг сайжруулах, бохирдлыг багасгах, иргэдийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд Мандалговь хотын төвийн золбин нохой устгах ажлыг гэрээгээр гүйцэтгүүлсүгэй.

2.Гэрээний дагуу хяналт тавьж, акт үйлдэн баримт бүрдүүлэхийг Хот тохижуулах газрын инженер (Ж.Базарсад)-д үүрэг болгосугай.

3.Нохой устгалын ажлын хөлс 6000000 (Зургаан сая) төгрөгийг Тамгын газрын бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас гаргахыг ня-бо (О.Бямбасүрэн)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА  Б.ОЮУНЧИМЭГ